

Энх тайвныг сахин хамгаалж болох бөгөөд Зөвлөлт Холбоот Улс ч империалист, милитарист бүлгийнхний түрэмгий санаархалд хариу няцаалт өгөх зориг шийдвэр төгс байна. Нөхөр Ю. В. Андроповын мэдэгдэлд ийм бат итгэлтэй зориг шийдвэр дүүрэн байна.

Зөвлөлт Холбоот Улсын тууштай санаачилгатай чиг бодлого, энх тайван, улс түмний аюулгүй байдал, хөгжил дэвшлийн үйл хэрэгт оруулж байгаа асар их хувь нэмрийг МАХН-ын Төв Хороо, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар өндөр үнэлж байна.

БНМАУ хүн төрөлхтний энх амгалан ирээдүйн төлөө Зөвлөлт Холбоот Улс болон ах дүү бусад орны хамтаар хойшид ч цуцалтгүй тэмцэх болно гэв.

**ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга,
ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга
Юрий Андроповын МЭДЭГДЭЛ**

МОСКВА. Есдүгээр сарын 28. (МОНЦАМЭ).

ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга Юрий Андроповын мэдэгдлийн бүрэн эхийг дор сийрүүлэв.

Олон улсын үйл хэрэгт АНУ-ын одоогийн засаг захиргааны баримтлан явуулж байгаа чиг шугамд өгч байгаа үнэлэлт дүгнэлтээ зөвлөлтийн хүмүүс, бусад ард түмэн, тэрчилэн улс орнуудын бодлогыг тодорхойлох талаар хариуцлага хүлээсэн бүх хүний сонорт хүргэх нь чухал гэж зөвлөлтийн удирдлага үзэж байна.

Товчоор хэлбэл, энэ бол энх тайванд ноцтой аюул занал учруулж байгаа милитарист чиг шугам юм. Бусад улс орон, ард түмний эрх ашгийг үл тоомсорлон, дэлхийд АНУ-ын ноёлох байр суурийг хангахыг оролдох нь энэ чиг шугамын мөн чанар юм.

АНУ-ын цэргийн хүч нөөцийг урьд өмнө үзэгдээгүй ихээр нэмэгдүүлж байгаа явдал, бүх төрлийн зэвсэг, тухайлбал цөмийн болон хими, ердийн зэвсэг үйлдвэрлэх өргөн хүрээтэй программ нь чухамдаа дээрх зорилгод захирагдаж байна. Зэвсэглэлээр ухаан жолоогүй хөөцөлдөх явдлыг АНУ одоо бүр сансарт дэлгэрүүлэхээр төлөвлөж байна.

Санаанаас зохиосон элдэв аян шалтаг заан АНУ-ын нутаг дэвсгэрээс олон мянган километрийн алсад америкийн цэргийн оролцоог өргөжүүлж байна. Зэвсэгт хүч хэрэглэн бусад улсын хэрэгт хөндлөнгөөс шууд оролцох, Вашингтоныхны шахалт тулгалтыг няцааж байгаа аливаа орны эсрэг америкийн зэвсгийг ашиглахын тулд түшиц газрууд байгуулж байна. Энэ бүхний уршгаар дэлхийн бүх нутаг орон, тухайлбал Европ, Ази, Африк, Ойрхи Дорнод, Төв Америкт түгшүүртэй байдал өслөө.

Вашингтоныхон энэ бүх аюултай төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд НАТО-гийн бусад орныг улам их татан оролцуулж байна. Түүгээр ч барахгүй японы милитаризмыг сэргээж, түүнийг энэ эвслийн цэрэг—улс төрийн машины хавсарга болгохыг чармайж байна. Ингэхдээ тэд өнгөрсөн үеийн сургамжийг албаар мартуулахыг хичээж байна.

Ард түмэн ямарваа засгийн газрын бодлогыг юуны өмнө түүний үйл ажиллагаагаар дүгнэдэг билээ. Иймээс АНУ-ын ерөнхийлөгч энх тайвны үйл хэрэг, улс түмний өөртөө засан тохинох эрх, бүрэн эрхт байдлын үйл хэрэгт үнэнч байдаг тухай НҮБ-ын индрээс хичнээн сүржин мэдэгдэл хийсэн ч ийм мэдэгдэл хэнийг ч ятган итгүүлж чадахгүй.

Хэрэв хэн нэг хүн америкийн одоогийн засаг захиргааны бодлогыг сайн тийш өөрчлөгдөж магадгүй гэж дэмий л итгэж байсан бол сүү-

лийн үеийн хэрэг явдал тэрхүү хоосон итгэлийг бүрмөсөн замхрууллаа. Америкийн одоогийн засаг захиргаа эзэнт улсын зорилгодоо хүрэхийн тулд ер нь аливаа сэтгэн боддог хүн тулж очоод зогсвол зохих заагийг давж гарахгүй байх тийм ямар нэг жолоо цулбуур вашингтоныхонд бий гэж огт итгэхээргүй тийм байдалд аль хэдийнэ хүрчээ.

Өмнөд солонгосын нисэх онгоцыг ашиглан АНУ-ын тусгай албадын зохион байгуулж маш нарийн бодож боловсруулсан өдөөн хатгалга ч улс төрийн бодлого дахь туйлын адал балмад явдлын жишээ юм. Бид энэ ажиллагааны бодит байдлыг үнэн мөнөөр нь ул үндэстэй илчилсэн билээ. Тэрхүү ажиллагааг зохион байгуулсан хүмүүс яаж ч булзан, ямарч хуурамч зүйл сэдэж гаргасан ч тэдний гэм буруу нэгэнт нотлогдсон юм.

Урьд өмнө гарч байгаагүй ийм ялт өдөөн хатгалгын уршгаар хүний амь хохирсонд харамсаж байгаагаа зөвлөлтийн удирдлага илэрхийлсэн билээ. Улсуудын бүрэн эрх, тэдгээрийн хил хязгаарын халдашгүй дархан байдлыг үл тоомсорлох эрхийг өөртөө олгохыг хүсч байгаа тэр хүмүүс, энэхүү өдөөн хатгалгыг сэдэж хэрэгжүүлсэн тэр хүмүүс, чухамдаа уг ажиллагааг үйлдсэний маргааш нь цэргийн асар их төсвийг конгресст батлуулахаар яаравчлан оруулж, одоо түүндээ бах тав нь ханаж байгаа тэр хүмүүс л ийнхүү хүний амь нас сүйдэхэд хүргэсэн юм.

Тэгэхлээр уг нисэх онгоцонд сууж явсан хүмүүс амь үрэгдсэний гэм бурууг бусдад тохохыг санаархан оролдож байгаа зүтгэлтнүүдийн «энэрэнгүй үзэл» гэгч нь «МХ» пуужингаас аваад мэдрэлийн саа тусгагч хий бүхий чингэлэг зэрэг үй олноор нь хөнөөн устгах зэвсгийн шинэ шинэ уул овоо болж хувирч байна.

Тэд хүнийг үзэн ядах аюултай бодлогоо аль нэг байдлаар үндэстэй болгохыг санаархан Зөвлөлт Холбоот Улс, мөн социализмыг нийгмийн байгууллынх нь хувьд зүсэн зүйлээр гүтгэж байгаа бөгөөд тэгэхдээ бүр АНУ-ын ерөнхийлөгч өөрөө үүнийг тухиран толгойлж байна. АНУ шиг ийм орны удирдагчид зөвлөлтийн ард түмнийг гутаах гэсэн зорилгодоо автаж ямар ёс суртахуунтай байх, яаж хүнлэг байхыг зусар чамин үгээр номлохын зэрэгцээ эх адаггүй харааж зүхэх нь холгүй байгаа явдал маш зохисгүй зүйл гэдгийг шууд хэлэх хэрэгтэй юм.

Ямар ёс суртахуунтай байхыг ингэж номлох нь юу болж хувирдгийг дэлхий дахин сайн мэднэ. Вашингтоны зүтгэлтнүүдийн ойлгодгоор бол тэр ёс суртахууныг Вьетнамд напалм, химийн хорт бодисын тусламжтайгаар ухуулж, Ливанд түүнийг хөлөг онгоцны их буугаар шингээж, Сальвадорт энэхүү ёс суртахууныг аймаглан устгах бодлогоор нэвтрүүлж байна. Ялт хэргийн энэ жагсаалтыг үргэлжлүүлж болно. Ингээд үзэхэд АНУ-ын бодлогын ёс суртахууны талтай холбогдсон зүйлийн тухайд өнөөдрийн байдлыг аваад үзсэн ч, өнгөрсөн түүхийг эргээд санасан ч бидэнд хэлэх юм байна.

Одоо вашингтоныхон төрийн зүтгэлтнүүд, улс гүрнийг төдийгүй, Нэгдсэн Үндэстний Байгууллагыг үл хүндэтгэн ёс суртахуун, эелдэг зан байдлын хамгийн наад захын журам горимын аль алиныг ч уландаа гишгэж байна. Энх тайван, аюулгүй байдлыг дэмжин сахиулах үүрэг зорилго бүхий олон улсын байгууллага цадигаа алдсан милитарист хийрхэл дэгдээж, сайн нэр төрийг нь доромжилж байгаа тийм оронд ер нь байрлаж таарах уу, үгүй юу гэсэн асуулт гарч байна.

Дэлхийн хувь заяаг гартаа оруулж авахыг санаархаж буй этгээдүүд коммунизмын эсрэг үзлээр халхавчлан няцаалт хүлээгээгүй газар бүрт өөрсдийнхөө санаанд нийцсэн дэг журам тогтоохыг хичээж байна.

Тийм маягийн ажил явууллагаа үндэстэй болгох гэсэн номнолыг том гүрний эрх баригчид өөрсдөө сурталдаж, зөвхөн тэгэхдээ бүр амаар номлоод зогсохгүй ажил болгон хэрэгжүүлээгүйсэн бол энэ үзэл баримтлалыг тоож анхаармаар юм биш л дээ.

Үзэл суртлын зөрчлийг улс хоорондын харилцааны хүрээнд шилжүүлэх нь гадаад хэрэгт тийм арга хэрэглэж байсан хүмүүст хэзээ ч сайн зүйл болж байгаагүй билээ. Тэгэх тусмаа одоогийн цөмийн эринд энэ нь бүр ч утга учиргүй, байж болшгүй зүйл юм. Үзэл суртлын сөргөлдөөнийг цэрэг дайны сөргөлдөөн болгох нь нийт хүн төрөлхтөнд асар их хохирол учруулахсан билээ.

Гэтэл коммунизмын эсрэг үзэлдээ харлаган болсон хүмүүс энэ талаар ухааран бодох чадваргүй байгаа бололтой. Тэд «зөвлөлтийн цэргийн аюул занал» гэгчээр айлгаж эхлээд одоо нийгмийн системийнх нь хувьд социализмын эсрэг «загалмайтны аян дайн» зарлаад байна. Дэлхий дээр социализмд ерөөс байр байхгүй гэдэг санааг хүмүүст ятган үнэмшүүлэхийг санаархаж байна. Гэхдээ Вашингтоныхон дэлхийг ямар байлгахыг хүсч байна вэ гэдэг дээр тулахаар үнэн санаагаа хэлэхгүй байна.

Гэвч хүсэл, бололцоо хоёр огт өөр өөр зүйл билээ. Түүхийн хүрдийг хэн ч ухрааж чадахгүй. ЗСБНХУ, социалист бусад орон өөрийнхөө хуулиар, тухайлбал нийгмийн хамгийн тэргүүний байгууллын хуулиар оршин тогтнож хөгжих болно.

Зөвлөлт төр оршин тогтносон 65 жилийнхээ дотор олон сорилт шалгалт түүний дотор хатуу ширүүн шалгалтыг амжилттай давсан билээ. Манай төр улсын бүрэн бүтэн байдал, түүний тусгаар тогтнол, манай байгуулалд халдсан этгээдүүд түүхийн хог дээр хаягдаж байсан юм. Манай орны аюулгүй байдал манай анд нөхөд, холбоотнуудын аюулгүй байдлыг бид ямар ч нөхцөлд хангаж чадна гэдгийг холбогдох бүх хүн ойлгох цаг болжээ.

Манай орны батлан хамгаалах чадвар нь хүчээ сорьж үзэхийг хэнд ч зөвлөмөөргүй тийм түвшинд байгаа гэдэгт зөвлөлтийн хүмүүс итгэл төгс байж болно.

Бид өөрсдийн зүгээс хүчээ тэгэж сорьж үзэх гээгүй байна. Энэ тухай бодох нь ч бидэнд харш юм. Бид манай ард түмний сайн сайхан байдал, зөвлөлт төрийн аюулгүй байдлыг тусгайд нь авч үздэггүй, тэр тусмаа бусад ард түмэн, бусад улс орны сайн сайхан байдал, аюулгүй байдлын өөдөөс сөргүүлэн тавьдаггүй юм. Цөмийн эринд дэлхий ертөнцийг хар амиа хичээсэн явцуу ашиг сонирхлын үүднээс харж болохгүй Төрийн хариуцлагатай зүтгэлтнүүдэд нэг л зам бий, тэр нь цөмийн дайны сүйрлийг сэрэмжлэн зайлуулахын тулд бүхнийг хийх зам юм. Үүнээс өөр аливаа байр суурь баримтлах нь харлаган, тэр ч байтугай аминд халгаатай хэрэг мөн.

Одоогийн хурц ээдрээтэй байдалд ч олон улсын үйл хэрэгт ямар чиг бодлого баримталбал зохих вэ? гэсэн асуулт зөвлөлтийн удирдлагад гардаггүй юм. Манай чиг шугам энх тайвныг сахин хамгаалж бататгах, түгшүүртэй байдлыг намжаан зөөлрүүлэх, зэвсэглэлээр хөөцөлдөхийг хазаарлан зогсоох, улс гүрний хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлэхэд урьдын адил чиглэж байна. Зөвлөлт Холбоот Улсын Коммунист Нам, зөвлөлтийн бүх ард түмний хувиршгүй хүсэл зориг ийм байна. Бүх улс түмний хүсэл мөрөөдөл ч мөн ийм гэдэгт бид итгэж байдаг юм.

Зөвлөлт Холбоот Улсыг хорсолтойгоор дайран давшлах нь бидний жигшил зэвүүцлийг зүй ёсоор төрүүлж байгаа боловч бид хүлээц тэвчээртэй улс. Бидний улс төрийн бодлого сэтгэлийн хөдлөлд тулгуур-

ладаггүй. Манай улс төрийн бодлогын үндэс нь эрүүл саруул санаа бодол, бодит байдал, дэлхий дахины хувь заяаны төлөө хүлээх гүнзгий хариуцлагад тулгуурладаг юм.

Хүн төрөлхтөн мөхөх учиргүй гэдгийг бид иш үндэс болгож байна. Зэвсэглэлээр хөөцөлдөхийг эцэс болгож болно, болгох ч ёстой. Үхэл таригч зэвсгийн дарамтад амьсгаа багтарч, хямрал мөргөлдөөнд идэгдсэн дэлхийд оршин амьдрахаас хавьгүй сайхан хувь тавилан хүн төрөлхтөнд бий.

Бид Европ дахь стратегийн болон дунд тусгалын цөмийн зэвсгийг хязгаарлан хорогдуулах талаар алсын хараатай санал дэвшүүлэхдээ зөвхөн ЗСБНХУ, социалист хамтын нөхөрлөлийн улсуудын аюулгүй байдал төдийгүй, бусад бүх улс орны аюулгүй байдлын төлөө санаа тавьж байгаа юм.

АНУ-ын бодлогын тухайд гэвэл улс орноо улам милитарчилж байгаа нь аль нэг байдлаар нухацтай хэлэлцээ хийж, зэвсэглэлээр хөөцөлдөхийг хазаарлан зогсоох асуудлаар хэлэлцэн тохирохыг хүсэхгүй байгаа явдлаар ч илэрч байна.

Тухайлбал Европ дахь цөмийн зэвсэглэлийг хорогдуулах тухай хамгийн хурц асуудлаар зөвлөлт—америкийн хэлэлцээ бүтэн хоёр жил үргэлжилж байна. Зөвлөлтийн талын байр суурь нь үнэнч шударга үндсэн дээр харилцан хүлээн авч болохуйц шийдвэр гаргах, хэний ч хууль ёсны эрх ашгийг хохироохгүй шийдвэр гаргах зорилготой юм. Харин Женевт хийж байгаа хэлэлцээнд оролцож байгаа манай түншүүд тэнд тохиролцохоор очоогүй болох нь энэ хоёр жилийн дотор бас тодорхой боллоо. Тэд цаг хугацааг сунжруулж, дараа нь Өрнөд Европт «Першинг—2» гэдэг баллистик пуужин, хол тусгалтай далавчит пуужин байрлуулахад шилжин орох гэсэн өөр зорилттой байна. Тэд үүнийгээ төдийлөн нуух ч үгүй байна.

Женевт хийж буй хэлэлцээн дээр АНУ уян хатан байдал гаргаж байгаа мэт үг яриагаар тэд өөрсдийгөө хаацайлж байна. Тун саяхан тийм бас нэг «уян хатан» байдал гэгч дүрээрээ гарч ирлээ. Энэ удаад ч гэсэн нөгөө хуурамч зальхай бодол нь тодорхой боллоо. Хэрэв зарим нарийн ширийн зүйлийг эс тооцвол «гойд сайн» хэмээн зарлаж буй америкийн байр суурьд гарсан шинэ зүйл гэгчийн мөн чанар нь урьдын адил зөвлөлтийн дунд тусгалын пуужинг хичнээнээр хорогдуулах, НАТО-д одоо нэгэнт байгаа цөмийн хүч нөөцөд нэмэлт болгож Европт америкийн шинэ пуужин хичнээнэийг байрлуулах тухай хэлэлцэн тохирох саналд л оршиж байна.

Товчоор хэлбэл Европын бүсэд буй дунд тусгалын цөмийн хэрэгслийн одоогийн тэнцвэртэй байдлыг НАТО-гийн эвсэлд ашигтайгаар алдагдуулахад нь тус эвсэлд яаж туслах тухай ярилцахыг бидэнд санал болгож байна. Тэд огтхон ч ичиж зоволгүй түүнийгээ шинэ зүйл гэгцгээж байна.

Вашингтоны эрх баригчид Европт америкийн цөмийн эдгээр пуужин байрлуулах ажиллагааг маш жирийн бөгөөд Европыг золиосонд гаргаад АНУ-д дээд зэргийн ашиг өгөх тийм зүйл гэж үзэж байна. АНУ Европын холбоотнуудаа барьцаанд өгч болно хэмээн үзэж байна. Энэ бол ичгүүр сонжуураа барсан илэрхий бодлого мөн. Харин өөрсдийнхөө ард түмний эрх ашиг, энх тайвны эрх ашгийг гаргуунд нь гаргаад АНУ-ын засаг захиргааны милитарист дээрэнгүй төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тусалж буй Европын улс төрийн зүтгэлтнүүд үүнийг эргэцүүлэн бодож байгаа эсэх нь даан ч ойлгогдохгүй байна.

Энд нэг зүйлийг бүрэн тодорхой хэлэх хэрэгтэй байна. Хэрэв Өрнөд Европын орнуудын хүн амын ихэнхийн хүсэл зоригийг үл тоомсорлон

америкийн цөмийн пуужинг Европ тивд байрлуулбал энэ нь АНУ-ын эрх баригчид болон тэдэнтэй нэг хударганд ажиллаж байгаа НАТО-гийн бусад орны зүтгэлтнүүдийн зүгээс энх тайвны үйл хэрэгт дайсагнасан ихээхэн аюултай алхам болно.

Стратегийн зэвсэглэлийг хязгаарлан хорогдуулах асуудлаар ч жинхэнэ ёсоор шийдвэр гаргах хүсэл америкийн талд байгаа нь бидэнд харагдахгүй байна. Одоо америкийн нийслэлд өөр зүйлээр хөөцөлдөж: тухайлбал ийм зэвсгийн шинэ шинэ системийг үйлдвэрлэлийн дамжлагад оруулсан байна. Ерөөс стратегийн тогтвортой байдлын тухай, цөмийн зэвсэглэлийг үр нөлөөтэй хязгаарлан хорогдуулах боломжийн тухай төсөөллийг үндсээр нь урвуулах стратегийн зэвсгийн тийм төрлийг үйлдвэрлэхээр бэлтгэж байна.

Зөвлөлт Холбоот Улсын сайн санаа, харилцан тохирох гэсэн хүслийг түүний сул доройн шинж тэмдэг гэж хэн ч үзэх ёсгүй. Цэрэг— стратегийн нэгэнт тогтсон тэнцвэртэй байдлыг эвдэх гэсэн аливаа оролдлогод Зөвлөлт Холбоот Улс зохих хариуг өгч чадах бөгөөд Зөвлөлт Холбоот Улсын ам, ажил хоёр зөрдөггүй юм.

Гэхдээ бид хүнийг үй олноор нь хөнөөн устгах зэвсэг үйлдвэрлэх, хуримтлуулах талаар уралдахыг зарчимтай эсэргүүцэгчид билээ. Тэгэж уралдах нь манай зам биш ээ. Тийм зам нь тухайлбал улсуудын эдийн засгийг хөгжүүлэх, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, хүмүүсийн амьдрал, тэдний хоол хүнс, эрүүл мэнд, боловсролын хамгийн наад захын нөхцөлийг бүрэлдүүлэх зэрэг хүн төрөлхтөний өмнө тулгарч буй нэг ч асуудлыг шийдвэрлэж чадахгүй юм.

Зэвсэглэлээр хөөцөлдөхөд ямар ч утга учиргүй үрэн таран хийж буй материаллаг нөөцийг хэмнэж, хүний бүтээн туурвих шавхагдашгүй боломжийг нээн илрүүлэх явдал л хүмүүсийг нэгтгэж, XX, XXI зууны заагт улс гүрнүүдийн бодлогыг тодорхойлох ёстой зүйл юм. Энэ бүхнийг хэрэгжүүлэхийн тулд милитаризмын хүчийг хазаарлан зогсоож, дэлхий ертөнцийг гүн ангал руу гулсан орох явдлаас хамтын хүч чармайлтаар аврах шаардлагатай байна.

Манай гаригийн бүх улс түмэн, хүн бүр заналхийлж буй аюулыг ухамсарлах ёстой. Аж төрлийнхөө төлөө тэмцэлд хүч чармайлтаа нэгтгэхийн тулд үүнийг ухамсарлах ёстой.

Хүн төрөлхтөн эрүүл ухаанаа алдаагүй, алдах ч ёсгүй. Энэ нь Европ болон бусад тивд пуужингийн эсрэг, дайны эсрэг хөдөлгөөн өргөн далайцтай өрнөж, тэр хөдөлгөөнд нийгэм, улс төр, шашны өөр өөр үзэл бодол бүхий хүмүүс оролцож байгаа явдлаар тод томруун илрэн харагдаж байна.

Зэвсэглэлээр ухаан жолоогүй хөөцөлдөхийн эсрэг, энх тайвныг хамгаалан, дуу хоолойгоо өргөж байгаа тэр хүмүүс Зөвлөлт Холбоот Улс, социалист бусад орны бодлого нь чухамхүү эдгээр зорилгыг хангахад чиглэж байгаад итгэл төгс байж болно. ЗСБНХУ бүх улс оронтой, түүний дотор АНУ-тай эв найртай аж төрөхийг хүсч байна. Манай улс түрэмгий төлөвлөгөө сэдээгүй, зэвсэглэлээр хөөцөлдөхийг хэнд ч шахаж шаардаагүй, нийгмийнхээ ёс горимыг хэнд ч тулган хүлээлгээгүй.

Бидний санаа бодол, хүсэл эрмэлзэл, олон улсын байдалд шийдвэрлэх сайн эргэлт гаргахад чиглэсэн тодорхой саналуудаар биеллээ олж байна. Зөвлөлт Холбоот Улс эх дэлхийнхээ энх тайвныг сахин хамгаалахын тулд хойшид ч бололцоотой бүхнийг хийх болно гэжээ.

«Үнэн» сонин. 1983 оны
Есдүгээр сарын 30